



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 482

Улаанбаатар хот

Б.Алтанцэцэгт хариуцлага тооцох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Захиралтай байгуулсан 2021/04/К дугаар контрактын 3.2.13, 6.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2021 оны а/3790 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захирал Б.Алтанцэцэг нь дээд байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, тогтоосон хугацаанд хариу өгч, тайлагнаж байх үүргээ удаа дараа биелүүлээгүй тул сануулах арга хэмжээ авсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг баримталж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Алтанцэцэгт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001427